



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

Үндэсний түшиц



БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН

Орон нутгийн хэрэгжүүлэгч



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
БОЛОВСРОЛЫН САН (FEE)-ИЙН
ГИШҮҮН

БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН
ТӨВ НҮТБ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

Улирал тутмын цахим сонин

Дугаар №2

2021 оны 1 дүгээр улирал

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

- “ТХБ-II” төслийн ТЗЗҮБ 2020 оны үйл ажиллагаагаа дүгнэлээ.
- “ТХБ-II” төслийн суурь судалгааг амжилттай хийж, гарааны нөхцлийг тодорхойллоо.
- Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөртэй холбоотой баримт бичгийн хүрээнд ТХБ-ын үзэл баримтлал туссан байдлыг шинжлэн судаллаа.
- Эх хэлний ОУ-ын өдөр тохиолоо.

2021 ОНД БҮХ ТҮВШИНД ХАМТАРЧ АЖИЛЛАХЫГ ЗОРЬЖ БАЙНА



“ТХБ-II” төслийн Техникийн зөвлөн зохицуулах баг /ТЗЗҮБ/ хоёрдугаар сард төслийн 2020 оны үйл ажиллагаагаа дүгнэж, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөлт, үндэсний болон Орон нутгийн түвшний хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоо, цаашид анхаарах асуудлуудаа хэлэлцлээ. Төслийн баг 2020 оны ажлын үр дүнгээ ингэж тодорхойлж байна.

ТХБ-БИД



“ТХБ-II” ТӨСЛИЙН
ТЗЗҮБ-ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ
О.ОЮУНТУНГАЛАГ:

“ТХБ-II” төслийг гурван гол үр дүнд хүргэхээр зорьж ажиллаж байна.

3-р “ТХБ-II” төслийн бас нэг үр дүн бол “ТХБ-I” төслийн үр дүнг бататгах, уялдаа холбоог сайжруулах, улам өргөжүүлэх явдал.

Энэ хүрээнд 1-р шатанд хийсэн томоохон ажлын нэг болох “ногоон ном”-ныхоо хүртээмж, агуулыг сайжруулан багш, эцэг эх, сурагчдад цувралаар хүргэхээр зорьж байна. Энэ бол багш нарт ТХБ-ын том гарын авлага болно. Энэ гарын авлага өөрөө ТХБ-ыг интеграцичилж, хичээлээр дамжуулан ТХБ олгох арга замыг хэлж өгөх онцлогтой.

Ийм байдлаар төслийн гол үр дүн богино хугацаанд гарлаа. Харин бид 2021 онд илүү томоохон ажилд төвлөрч, бүх түвшинд хамтарч ажиллахыг зорьж төлөвлөж байна.



МОНГОЛЧУУДЫН ХОГ
ХАЯГДЛЫГ БУУРУУЛЖ
БҮЙ ТҮРШЛАГЫГ
ДЭЛХИЙ ДАХИНАА
МЭДЭЭЛНЭ

ТХБ төслийн Олон
улсын зөвлөх
Мита Нангиа Госвами

1-рт ТХБ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх төвшний хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, тэдний мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

Энэ үр дүнг хэрэгжүүлэхээр төслийн түшиц байгууллага Боловсролын хүрээлэнгийн удирдлага, манлайллын дор мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдээс бүрдсэн техникийн зөвлөн зохицуулах үндэсний баг /ТЗЗҮБ/ ажиллаж байна. “ТХБ-II” төслөөс өнгөрсөн онд ТЗЗҮБ-ийн гишүүддээ 4-5 удаагийн сургалт зохион байгуулсан. Эдгээр сургалтын хүрээнд ТЗЗҮБ-ийн гишүүд өөр өөрсдийн байгууллагынхаа ажилтнуудын дунд сургалт хийлээ. Давхардсан тоогоор 341 хүний мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд төслөөс зохих дэмжлэг үзүүлээд байна. “ТХБ-II” төсөл бүх төвшний үйл ажиллагаанд эргэтэйчүүдийн оролцоог 20-иос доошгүй хувиар барих зорилт тавьсан. Одоогоор сургалтад хамрагдагчдын 23.1 хувь нь эрэгтэйчүүд байна.

Техникийн зөвлөн зохицуулах багийн гишүүн 9 байгууллага тус бүрд “ТХБ-II” төслийн багийн хоёр гишүүнээ дэмжсэн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй Тогтвортой байдлын хороо ажиллаж байна. Эдгээр хороод хоёр гишүүнтэйгээ хамтраад байгууллагынхаа үндсэн хүний нөөцөө сайжруулахад хамтарч ажиллаж байгаа юм. Учир нь бид өнөөдөр бүх түвшинд хамтарч, түншилж, бие биенээ ойлгож байж хамтаараа амжилтанд хүрнэ. Түншлэл, хамтын оролцоо, хамтын санаачлагыг илүү хөхүүлэн дэмжихийг дэлхий нийтээрээ гол болгож байгаа учраас төсөл маань энэ чиглэлд анхааран ажилладаг.

2-т “ТХБ-II” төслийн бас нэг гол үйл ажиллагаа нь судалгаа.

Бид Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдынхаа тусламжтай сургалтын хөтөлбөртэй холбоотой бодлогын баримт бичгүүдэд ТХБ-ын чиглэлээр дүн шинжилгээ хийлээ. Бодлогодоо гол асуудлаа суулгадаг байх, хэрэгжилтэд анхаарч, дэмжлэг үзүүлэх, эргэх холбоон дээр бүх түвшинд хамтарч ажиллах зэрэг шаардлага байгааг судалгааны дүн харуулж байна.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II” ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН МАТРИЦ



Түншлэл - Хамтын ажиллагаа - Хөгжил

ТХБ төслийн Олон улсын зөвлөх Мита Нангиа Госвами хог хаягдлыг бууруулах монголчуудын санал санаачлагыг ирэх 5-р сард болох Тогтвортой хөгжлийн боловсролын дэлхийн форумоор мэдээлж дэлхий дахинд хүргэнэ гэлээ. Тэрээр:

“Ковид-19” цар тахал өнөөдөр дэлхий дахиныг бүхэлд нь хэцүү байдалд оруулж байгаа нь биднийг амьдралын хэв маягаа эргэн харж амьдралаа илүү тогтвортойгоор дахин төлөвлөх арга замаар амьдрах хэрэгтэйг ойлгуулж байна. ТХБ нь өнөөгийн болон хойч үеийнхнийхээ төлөө соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх хэдий ч байгаль орчны эко системээ хадгалж, нийгмийн шударга ёсыг хангаж, эдийн засгийн хувьд амьдрах чадвартай байж, мэдлэг, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах эрх мэдэл олгож буй явдал. Насан туршидаа суралцах нь чанартай боловсролын чухал нэг хэсэг юм.

ЮНЕСКО-ийн холбоот сургуулиудын сүлжээ, ДБОБС хамтран хог хаягдлын менежмент, бүр цаашлаад тогтвортой хөгжлийн талаар суралцах үйл явцад оролцохыг гишүүн орнууддаа уриалсан. Тухайлбал, “Траш хак” хөтөлбөр хувирган өөрчлөлтийн төлөөх үйл ажиллагаанд суурилсан аргачлал юм. Өдрийн хоолоо өөрийн сав, савхтай авч явах нь энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж буй энгийн жишээ гэдгийг олон улсын хөтөлбөрийн зохицуулагч Жули Сатно хэлж байв.

Олонхийг хамарсан үед л энэ нь тогтолцооны өөрчлөлтийг авчирдаг. Тухайлбал хүмүүс олноороо хоолоо өөрийн саванд хийж явснаар хуванцар, нэг удаагийн савтай хоол хүргэлт багасч, эрэлт хэрэгцээ буурна. Ингэснээр дэлхийн нөөцийн эх үүсвэрт үзүүлэх дарамт багасна юм.

Та бүхэн энэ талаар хийж буй ажлын мэдээлэл авахыг хүсвэл TRASHACK.ORG сайтад хандан, багшийн гарын авлагыг татаж авах боломжтой. Мөн өөрсдийн хийж буй санал санаачлагын талаар ирэх 4-р сар гэхэд бидэнд мэдээлэл 5-р сарын 17-оос 19-ны өдрүүдэд Берлинд болох Тогтвортой хөгжлийн боловсролын дэлхийн форумын үеэр та бүхний мэдээллийг дэлхий дахинд мэдээлэх юм” гэсэн байна.

ГАРЧИГ

БИД: “ТХБ-II” төслийн үйл ажиллагааны үр дүн	1
ЗОЧИН: МУИС-ийн ЭШИА-ны дарга, доктор Я.Шийлэгмаа	2
СУДАЛГАА: “ТХБ-II” төслийн суурь судалгааны танилцуулга, дүн	3
ҮЙЛ АЖИЛЛАГАА: МХЕГ-аас бэлтгэв	4
ҮЙЛ АЖИЛЛАГАА: /Үргэлжлэл/	5
ШИНЖИЛГЭЭ: ТХБ-ын үзэл баримтлал ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөртэй холбоотой баримт бичигт туссан байдал	6
НЭГ СЭДВЭЭР: ОУ-ын эх хэлний өдөрт	7
ОРОН НУТАГ: Хэнтий аймгаас...	8



Тогтвортой хөгжлийн зарчим, үнэт зүйл, туршилагыг бүх түвшний боловсрол, сургалтын үйл ажиллагаанд нэгтгэн оруулахад Тогтвортой хөгжлийн боловсролын зорилго оршидог. Тиймээс ч Монгол улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газрын дэлжлэгээр хэрэгжүүлж буй "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн түши болон төсөл халтран хэрэгжүүлэгчдэд БШУЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт МУБИС, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндэсний төв гээд боловсролын салбарын байгууллагууд түлхүү ордог. Энэ удаа бид МУБИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн албаны дарга, доктор Я.Шийлэгмаатай ярилцлаа.

Тогтвортой хөгжлийн үзэл санааг сургалтын хөтөлбөр, агуулгадаа шингээж, түүгээр дамжуулан ТХБ олгох үйлсэд тэргүүнд яваа сургуулиудад МУБИС орох болов уу гэж бодож байна. Ер нь ийм хэрэгцээ шаардлага хэрхэн тулгарч байна гэдгээ яриагаа эхлэх үү?

Баярлалаа. Эрхэм уншигч нартаа "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн багийн хамт олны өмнөөс мэнд хүргэе. Дэлхийн ертөнцийн өөрчлөлтийг дагалдаад унших, бичих чадвараас гадна тогтвортой хөгжлийн чадвар хүн бүхэнд чухал болжээ. Учир нь аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын эринд хиймэл оюун, робот, нано технологи, биотехнологи, ухаалаг хот, кибер систем нь нийгмийн амьдралын бүхий л орчинд маш хурдтайгаар нэвтэрч байна. Судлаачдын үзэж байгаагаар 2030 он гэхэд нийт ажлын байрны 60 хувь нь автомат горимд шилжиж 375 сая хүн ажлаа солих, эсвэл шинэ мэдлэг чадвар эзэмших хэрэгтэй болно. Тиймээс шинэ зууны боловсролыг тогтвортой хөгжлийн боловсрол хэмээн үзэх гол үндэслэл нь энэ болоод байна. Энэ бүхнийг эргэцүүлээд үзэхээр боловсролыг бид хүссэн хүсээгүй шинэчлэх шаардлага байна. Энэхүү шинэ орчинд дээд боловсролын салбарт тогтвортой хөгжлийн үзэл санааг тусган сургалт, судалгааны брэнд хөтөлбөрүүд хэрэгжүүлж, зах зээлийн динамикийг сайтар мэдэрч ажиллах нь стратеги бодлогын чухал чиглэл болж байна. Өнгөрсөн зуунд "Байгалиас хишиг горьдож суухгүй, харин түүнийг булаан авах хэрэгтэй" гэсэн үзэл ноёрхож байсан. Тэрхүү үзлийн сөрөг үр дагаварт хүн төрөлхтөн нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудтай тулгарч, байгаль эх маань доройтсон. Бид нэг л дэлхийтэй. Монголчууд эрт дээр үеэс байгалийн нөөц баялгийг зохистой ашиглаж, байгаль орчиндоо зохицон амьдарч ирсэн нүүдлийн соёл, уламжлалтай улс. Гэсэн ч сүүлийн 50 гаруй жилд улс орны эдийн засаг хөгжиж, хотжилт явагдахын хирээр байгаль орчин доройтож, байгалийн нөөцийн зохисгүй ашиглалтаас болж байгалийн онгон дагшин байдал, экосистемийн тэнцвэрт байдал алдагдах боллоо. 1992 онд Рио-Де-Жанейро хотод болсон уулзалтаас дэлхийн экосистем улам доройтож байгаа тул тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх гол хэрэгсэл нь боловсрол юм хэмээн тодорхойлсон. Нобелийн шагналт эдийн засагч Роберт Шиллерийн

Я.ШИЙЛЭГМАА: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ БОЛ ШИНЭ ЗУУНЫ БОЛОВСРОЛ ЮМ

"Байшингаа галд өртөхөөс нь өмнө даатгалаа хийлгэх хэрэгтэй" гэсэн чухал сануулгыг одоо л хүн төрөлхтөн ойлгож, олон ажлыг санаачилж байна. Энэ бол Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол юм. Үүнийг хэрэгжүүлэх олон арга зам бий. Гэхдээ энэхүү олон арга замын хамгийн үр дүнтэй нь багш бэлтгэх их сургуулийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, агуулга, аргазүйг тусгах явдал юм.

Яг энэ асуудлыг тодруулаар байна. Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгыг МУБИС хичээлийнхээ болон бусад үйл ажиллагааны хөтөлбөртөө хэрхэн тусгаж байна?

Ирээдүй үеийнхэнд тогтвортой хөгжлийн боловсролын чадвар эзэмшүүлэх, generation буюу 1995 хойш төрсөн үеийнхэнд зориулсан боловсролын шинэчилсэн хөтөлбөрүүдийг боловсруулах чиглэлээр МУБИС олон ажлыг санаачлан хийж байна. Боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх талаар олон улсын төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд томоохон судалгаа явуулж, илтгэл, тайлан, ном бүтээл хэвлүүлж, орон нутгийн багш нарт сургалт семинар хийж, аргазүйг эзэмшүүлэн ажиллалаа. Түүнчлэн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн агуулгыг ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан шинэчлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр МУБИС-ийн санхүүжилттэй төслийн санхүүжүүлэн хэрэгжүүллээ. Мөн багшийн мэргэжлийг дээшлүүлэх, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн агуулгад ТХБ-ын үзэл санааг тусган ажиллаж байна.

Бид "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн хүрээнд 2020 онд МУБИС-д Тогтвортой байдлын хороог байгуулж, хорооны үйл ажиллагаагаараа дамжуулж, ТХБ-ыг түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. МУБИС-д "Боловсролын суурь судалгааны төв"-ийн дэргэд тогтвортой хөгжлийн боловсролын секторыг байгуулан ажилласнаар багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг өөрчилж шинэчлэх, сурган хүмүүжүүлэх арга технологийг өөрчлөх, сурагчдыг хүйс, арьсны өнгө, угсаа гарлаар нь ялгаварлан гадуурхахгүй байх талаар ойлгуулах, оюутнууд өөрсдөө сургалтын хөтөлбөр боловсруулж, туршиж хэрэгжүүлэх, багш болох оюутнуудад ТХБ модулийг боловсруулах чадварыг эзэмшүүлэх зэрэг олон чиглэлээр ажиллаж байгаа нь ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан бүх шатны сургалтыг шинэчлэх үйл явц хэмээн харж байна.

МУБИС энэ онд ногоон оффис байгуулах, хог хаягдлын менежментээ сайжруулах зорилт тавиад ажиллаж байна. Ямар үр дүн хүлээж байна?

Бид байгууллагаа 2021 онд "Ногоон оффис" болох зорилго тавьж, олон ажлуудыг хийж эхлээд байна. Хогоо ангилан ялгагдаг дадлыг багш, ажилтанд хэвшүүлэхийн тулд хог ангилан ялгах савыг санамжийн хамт байршуулсан. Тэр саванд ангилан ялгах санамж байх тул хогоо хаяхдаа хүртэл жижигхэн мэдээлэл авах нь бас л нэг мэдлэг шүү дээ. Бид өөрчлөлтийг өөрийн өдөр тутмын энгийн дадал хэвшлээс эхлэхэд болно хэмээн үзэж энгийн ажлуудыг хүртэл төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. МУБИС дээр төслийн дэмжлэгтэйгээр Тогтвортой байдлын хороо ажиллаж байгааг дурдсан. Zero waste, минималист амьдралын хэв маягууд, гялгар уут, хуванцар савнаас татгалзах, хаягдал зай



хадгалах сав байршуулах, хоолны хаягдалгүй амьдрах, гэрэл, компьютерээ унтрааж занших, усаа хэмнэх гээд дурдаад байвал олон зүйл байна. Эцэст нь хэлэхэд НОГООН бол зүүгээр ч нэг өнгө биш, энэ бол амьдралын философи юм гэдгийг хэлмээр байна.

Ногоон оффисыг бүтээж байгаа алхам, арга хэрэгслээс онцолбол?

Эрчим хүч гарган авахын тулд их хэмжээний нүүрс шатааж, цаас үйлдвэрлэхийн тулд ой мод устгаж байгаа зэрэг нь дулаарлын гол шалтгаан болдгийг хүн бүхэн мэддэг. Гэсэн ч түүнийг өөрчлөхийн төлөө мэдэж байгаа шигээ хангалттай ажиллаж чаддаггүй. Бид ногоон орчныг бий болгохын тулд эхний ээлжинд эрчим хүч, усыг үр ашигтай хэрэглэх талаарх сургалт, нөлөөлөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Ингэхийн тулд эхний ээлжинд "ногоон худалдан" авалт хийх хэрэгтэй. Байгууллагын албан өрөөнд худалдан авч байгаа бүтээгдэхүүн нь ENERGY STAR® логотой байхыг шаардаж байна. Эдгээр бүтээгдэхүүн нэг талаар соёлтой хэрэглээ боловч нөгөө талаараа та бидний амьдарч байгаа эх дэлхийн дулаарлыг сааруулж, сөрөг өөрчлөлтийг бууруулахад голлох байр суурь эзэлдэг. Мөн дахин ашиглагдах боломжтойг сонгохыг худалдан авалт хариуцсан ажилтнууддаа зөвлөн ажиллаж байна. Бидний хэрэглэж байгаа компьютер, мониторын зарцуулж буй цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний 85-95 хувийг эзэлдэг тул шинээр худалдан авахдаа энэ бүхний тооцох хэрэгтэй юм. Тиймээс ч амрах горимд программчилж болдог принтер, факс зэрэг бүтээгдэхүүнийг сонгох талаар хариуцсан албан тушаалтнуудад сургалт хийх зэргээр өөрчлөлтүүд хийж эхэлж байна.

Үнэндээ зарим албан газруудын гэрэл өдөржин асаалттай байдаг. Эдгээр гэрэл нь хэдий хэмжээний эрчим хүчийг зарцуулж байгааг бүгд мэддэг хэрнээ огт анзаардаггүй. Тиймээс өдрийн цагт гэрлээ унтраах, цонхоо аль болох цэвэрхэн байлгаж, гэрэл нэвтрэх боломжийг бий болгож өгөх нь таны тогтвортой хөгжилд оруулж буй томоохон хувь нэмэр гэдгийг байгууллагын түвшинд сургалт хийж буй нь эерэг хандлага хэмээн харж байна. Нэг л жишээ дурдахад, ердийн өдрийн гэрлийг өндөр үр ашигтай электрон балласттай гэрлээр сольсноор эрчим хүчний хэрэглээ 40-50 хувь буурна. Орчин үеийн хамгийн үр ашигтай гэрэлтүүлэг нь LED лампууд.


Энэчлэн бидэнд ТХБ оюун санаа, сэтгэлгээ, мэдлэгийн их нөөц байна.

Хөгжлийг бүтээж, хөтөлж явах чадвартай монгол хүнийг хөгжүүлэгч багш бэлтгэх ууган их сургуулийн 70 жилийн ойг угтаж бид тогтвортой хөгжлийн боловсролыг байгууллагын түвшинд улам хөгжүүлэх олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж буйг дуулгахад таатай байна.


Баярлалаа.



“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ-II” ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ДҮН



СУРАГЧИД



АНГИ	ХҮҮХЭД	%
8 анги	600	36.1%
9 анги	548	32.9%
10 анги	516	31.0%



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Макро | 84.6

- Макро түвшний ТЗЗҮБ-ийн үйл ажиллагааны үнэлгээ-84.6%


Меззо | 65.2

- ТХБ-II төслийн сургуулийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд өгсөн үнэлгээ-66.1%
- ТЗЗБ-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд өгсөн үнэлгээ-64.3%


Микро | 21.5

- ТХ-ийн ЕБС-ийн сурагчдын ТХБ-ын мэдлэг-10.8%
- ТХ-ийн төлөөх ЕБС-ийн эцэг эхийн хариултын нийлбэр-26.7%
- Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хувь (багш-21.9%, сурагч-19.7%, эцэг эх-13.2%)
- ТХБ-ын мэдлэг, ойлголт, чадвар, хандлагын өөрчлөлтийн байдал-37.2%


ТХБ-ын талаар сурагчдын мэдлэг



ТХБ-ын талаарх эцэг эхчүүдийн мэдлэг



ОРОН НУТАГТ ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭЭР ГАРГАСАН САНАЛЫН ХУВЬ (ТӨСЛИЙН СУРГУУЛЬ)



ОРОН НУТАГТ ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭЭР ГАРГАСАН САНАЛЫН ХУВЬ (ХЯНАЛТЫН СУРГУУЛЬ)



СУДАЛГААНЫ ДҮН

Суурь судалгааны үр дүнд тулгуурлан төслийн гарааны нөхцлийн үзүүлэлт, үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг авч үзэхэд макро түвшинд үйл ажиллагаа тогтмолжсон “сайн” буюу 84.6% байгаа бол, мезо түвшинд дунд буюу 65.2%, харин микро түвшинд гарааны үйл явц эхлэл төдий буюу 21.5%-тай үнэлэгдсэн байна.

Төслийг хэрэгжүүлж буй дээд түвшинд оролцогчдын үйл ажиллагаа сайн байгаа нь цаашид дунд болон бичил түвшинд төслийн үйл ажиллагаа сайжрах боломжтой гэж суурь судалгааны баг үзэж байна.



СУРГУУЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГА БИЙ

“Тогтвортой Хөгжлийн Боловсрол II” төслийн техникийн зөвлөн зохицуулах багийн гишүүн байгууллага МХЕГ нь “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага (СБААХ)-ын өөрийн үнэлгээний арга аргачлал болон сургуулийн үйл ажиллагааг үнэлэх хяналтын хуудас (check list) -ны тохиргоог хангах хүрээнд тодорхой ажлуудыг хийгээд байгаа юм. Ажлын үр дүнгийн талаар ТХБ II төслийн ТЗЗҮБ-ийн гишүүн, МХЕГ-ын албан дарга, доктор /Ph.D/, дэд профессор М.Нямсүрэнтэй ярилцлаа.

Хяналтын хуудасны тохируулга хийх ажлын үр дүнгээ та бүхэн хэрхэн тодорхойлж байна?

Манай байгууллага “ТХБ-II” төслийн ТЗЗҮБ-ийн гишүүн байгууллагын хувьд ТХБ-ийн зорилтын хэрэгжилтийг сайжруулахын тулд Мэргэжлийн хяналтын байгууллагын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас (check list)-ны шалгуур үзүүлэлтийг “Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв”-ийн боловсруулсан “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага”-ын өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, арга аргачлалтай тохируулан сайжруулалт хийх гэрээт ажлыг хийж гүйцэтгэлээ. Тохироц, сайжруулалтын ажлыг хийснээр нэгжийн түвшинд тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт сайжирч, хяналтын байгууллагын хувьд бодлогын баримт бичгийг хуульчлан биелүүлэхийг шаардах замаар боловсролын системийн тогтвортой байдлыг хангахад чиглэх юм. Улмаар сургууль өөрийгөө үнэлэх арга зүйд сурч, эрх зүйн актаар баталгаажсан хяналтын хуудасны шалгуурт тохируулан тогтвортой хөгжих арга хандлагаар бүх нийтээр даган мөрдөх үр нөлөө үзүүлнэ.

Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагын өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, мэргэжлийн хяналтын байгууллагаас сургуулийн үйл ажиллагааг үнэлэх хяналтын хуудас (check list) хоёр ямар ялгаатай байсан бол?

Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулийн СБААХ-ын бойжилтын түвшинг (агуулгын айгаар) тодорхойлсон графикаас харахад хүний нөөцийн чадавхийн хөгжил 1.91, сургууль, сургалтын орчин 1.86 байгаа нь бусад үзүүлэлтүүдийн дунджаас дээгүүр, эхлэлийн түвшнээс зохицуулагдах түвшинд шилжиж байгаа нь ажиглагдлаа. Иймээс эхлэл оролдлого хийж байгаа эдгээр сайн ажлыг ахисан шатанд хүргэхэд хяналтын байгууллагаас тэднийг дэмжих, шахаж шаардах ажлыг хамт явуулах хэрэгтэй гэж үзсэн.

Өнгөрсөн онд Мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд 6.2. кодтой ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар 186 ерөнхий боловсролын сургуулийг хянаж шалгасан үнэлгээг нэгтгэхэд 5100 гаруй зөрчил илэрсэн. Эрсдэл үүсэх магадлал 27.19 хувьтай үнэлэгдсэн. Гүйцэтгэлийн хяналт шалгалтын мэдээллээр 1500 гаруй зөрчил бүртгэгдэж эрсдэл үүсэх магадлал 8.11 хувьтай байлаа. Гүйцэтгэлийн хяналтаар 460 гаруй зөрчлийг арилгуулсан. Нийт зөрчлүүдийг хяналтын хуудасны бүлгээр авч үзэхэд Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандартын шаардлагыг /MNS6782:2019 стандарт/ 46 хувь нь бүрэн хангаагүй зөрчилтэй байсан. Тиймээс бид энэ удаад хяналтын хуудасны сургуулийн

орчны аюулгүй байдал бүлгийг сонгон авч тохируулга хийж, өөрчлөн сайжруулсан

СБААХ-ыг нэвтрүүлж буй загвар сургуулиудын бойжилтын түвшинг өсгөхөд мэргэжлийн хяналтын байгууллагаас сургуулийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудасны шалгуур үзүүлэлтийг шинэчлэн сайжруулж, сургуулиудын ТХБ-ын чиглэлээр санаачлан хийсэн ажлыг үнэлдэг болох нь чухал юм. Тиймээс энэ төслийг хэрэгжүүлэгч багийн гишүүд бид хяналтын хуудасны шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах зорилгоор хууль эрх зүйн баримт бичгүүдийг дахин шүүж, ТХБ-ын үндсэн агуулга, зорилтуудыг тусган өөрчлөх ажлуудыг хийлээ.

Дээрх хоёр хяналтын хуудасны бүлэглэл, шалгуур үзүүлэлтийг харьцуулан судлахад ТХБ-ын цөм агуулга, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний үзүүлэлтүүд мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын хуудаст тусгагдаагүй, түүнчлэн сургуулиудын өөрсдийн идэвх санаачлагаар эко орчин бүрдүүлэх, экологийн ул мөрөө бууруулах чиглэлээр хийсэн ажлууд нь үнэлэгдэхгүй, дэмжигдэхгүй өнгөрөх байдал үүссэн нь ажиглагдлаа. Мөн түүнчлэн орчны аюулгүйн үзүүлэлтийг хүүхдийн эрх болон жендерийн мэдрэмжтэй байдлаар зохицуулсан эсэхэд огт анхаараагүй дутагдал байна гэж үзэж, сайжруулах ажлыг хийлээ. Харин СБААХ-ын өөрийн үнэлгээний бүхий л шалгуурыг мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын хуудаст оруулах боломжгүй байна. Энэ нь хууль эрх зүйгээр баталгаажих зохицуулагдаагүй, зөвхөн хүний эрхийн тунхаг, хөгжлийн хөтөлбөрт туссан байгаа зэргтэй холбоотой юм.

Хяналтын хуудасны “Сургалтын орчны аюулгүй байдал” бүлгийн сайжруулалтын үр дүнг тодорхойлвол?

Сургууль, сургалтын орчны аюулгүй байдлын шалгуурыг дараах байдлаар өөрчлөн орууллаа. Сурагчдад тав тухтай ногоон орчин бүрдүүлж, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалсан хяналтын камертай, тэдний бие бялдрын хүмүүжил олгох /биеийн тамирын хичээлийн талбай/ болон бусад үйл ажиллагаа явуулахад зориулан тохижуулсан гадаа талбайтай, барилга, байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих нөхцөл, шаардлагыг хангасан байх зэрэг шалгуурыг тавьж байна.

Түүнчлэн хүүхдийн эрх, нас биеийн онцлог, хүйсийн ялгамжтай байдалд тохируулан эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зориулалтын өрөөг жендерийн мэдрэмжтэй байдлаар зохион байгуулан тохижуулсан байдал, хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагаа явуулах анги танхим, талбайн хүрэлцээ, тусгай нөхцөл шаардлагад нийцсэн орчин нөхцөл бүрдүүлж, тохижуулсан 16 настай, хөгжлийн бэрхшээлтэй,



МХЕГ-ын Боловсрол, соёлын хяналтын хэлтсийн дарга, доктор /Ph.D/, дэд профессор М.Нямсүрэн

эмэгтэй хүүхдэд зориулсан г м \ гэсэн 6 шалгуурыг нэмж, өмнөх хяналтын хуудсанд хичээлийн кабинет бүрээр шалгуур гарган үнэлдэг байсныг бүлэглэн өөрчиллөө. Байгалийн ухааны хичээлүүдийг /математик, физик, хими, биологи, ургамал, амьтан судлал г м/ шаардлага хангасан кабинет, лабораторитой, тэдгээрийн тохижилт нь сурагчдад экологийн ул мөрийг багасгах дадал хэвшилтэй болоход зориулагдсан, дуу хөгжим, амьдрах ухаан, эрүүл мэндийн хичээлийн кабинетүүдийг ТХБ-ын агуулгад нийцүүлэн тохижуулсан гэх зэргээр нэгтгэн сайжруулсан.

Сайжруулан боловсруулсан хяналтын хуудасны шалгуурын хууль эрх зүйн үндсийг судлан тогтоож, “Сургалтын орчин бүлгийг өөрчлөх хувилбар”-ыг боловсруулан аймаг, нийслэлийн боловсролын улсын /ахлах/ байцаагчдаас санал авч нэгтгэлээ. Шинэчлэн боловсруулсан хяналтын хуудсыг Шадар сайдаар батламжлуулан Мэргэжлийн хяналтын шилэн хяналтын цахим системд байршуулснаар Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, шалгуурын дагуу үнэлүүлэх боломжтой болж байгаагаараа ач холбогдолтой юм.

Цаашид боловсролын чиглэлээр хяналт шалгалт хийдэг хяналтын хуудаснуудад ийм тохируулга хийх үү.

Энэ удаагийн хяналтын хуудаст тохируулга хийх гэрээт ажил нь ЕБС-ийн үйл ажиллагааг шалгах 6.2 кодтой хяналтын хуудасны “Сургуулийн орчны аюулгүй байдал” бүлгийн тохируулга байсан төдийгүй их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шалгах хяналтын хуудаснуудад тодорхой хувилбараар тохируулгыг тусгаж сайжруулсан. Цаашид хяналтын хуудсыг бүлэг бүрээр авч үзэн боловсронгуй болгох шаардлагатай байна. Ингэснээр бидний хамтын ажиллагаа биеллээ олж, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх үйл явцад сайнаар нөлөөлж, Монгол улсын тогтвортой хөгжилд тодорхой хувь нэмэр болно хэмээн үзэж байна.

Баярлалаа.





“ТХБ-II” төслийн ТЗЗҮБ-ийн гишүүн байгууллагуудынхаа үйл ажиллагааг бид цувралаар хүргэж байгаа юм. Энэ удаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас мэдээллээ бэлтгэлээ.


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХЯНАЛТЫН ХУУДАС АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ



Мэргэжлийн хяналтын байгууллага 40 эрсдэлийн шалгуураар 277 хяналтын хуудсаар 145 000 объектод 2015-2020 онд эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт явуулсан байна. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд хяналтын хуудсыг үнэ төлбөргүй таган авч дотоодын хяналт шалгалтдаа ашиглах боломжтой. Хяналтын хуудас нь хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, үнэлгээг бодитой болгох, хууль тогтоомж, стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ач холбогдолтой.

ХЭРЭГЛЭГЧ ХЯНАХ ЭРХТЭЙ



Мэргэжлийн хяналтын байгууллага аж ахуйн нэгж, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад хэрэглэгчийн хяналт, хариуцлага, мэдлэгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор хэрэглэгчийн хяналтын хуудсыг боловсруулан <http://inspection.gov.mn> –д байршуулсан.

Хэрэглэгчийн хяналтын хуудсанд заасан шаардлагыг тухайн байгууллага биелүүлээгүй тохиолдолд Мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж болно. Хэрэглэгч хянах эрхтэй.

62 000 ОБЪЕКТОД ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ



Төрийн байгууллагаас хувийн хэвшилд хийгдэж байгаа хяналт, шалгалтын давтамж, хамрах хүрээ, аж ахуйн нэгжийн ачааллын талаарх бодитой мэдээллийг бүртгэх, харуулах зорилготой шилэн хяналтын систем ажиллуулж байна.

2020 онд Мэргэжлийн хяналтын байгууллагаас үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 62 000 гаруй объектод эрсдэлийн үнэлгээ хийжээ.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДАВТАМЖИЙГ БУУРУУЛЛАА

Мэргэжлийн хяналтын байгууллага нь хяналт шалгалтын үйл ажиллагаанаас гадна хэрэглэгч, бизнес эрхлэгчдэд үүсч болох эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгон, соён гэгээрүүлж, зөвлөн туслахад анхаарч ажиллаж байна.

2020 онд 69 500 гаруй объектод шалгалт явуулж, олон хэлбэрээр хяналт тавьснаас 32,5 хувь нь

шалгалт, 67,5 хувь нь тандалт судалгаа, зөвлөн туслах үйлчилгээ, баталгаажуулах үйл ажиллагаа байлаа.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 150 шахам объектод эрсдэлийн үнэлгээ хийхэд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдэл ихтэй нь 14.5 хувь, дунд нь 57.8 хувь, эрсдэл бага 27.7 хувь гэж үнэлэгдсэн байна.

“ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ-ХЭРЭГЛЭГЧТЭЙ ХАМТАРСАН ХЯНАЛТ” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Энэ 2021 оноос ХХМТГ-тай хамтарч Мэргэжлийн хяналтын ерөнхий газар “Дижитал шилжилт - Хэрэглэгчтэй хамтарсан хяналт” төсөл эхэллээ. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр технологийн өөрчлөлтөд тохирсон хөгжлийн бодлогоо тодорхойлон, дижитал дэд бүтцийг байгуулж, иргэд хэрэглэгчтэй хамтарсан хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинэ загварыг боловсруулах, иргэд, хэрэглэгч, аж ахуйн нэгж байгууллагуудтай харилцан мэдээллээ шуурхай солилцож, ухаалаг үйлчилгээг хүргэжээр ажиллаж байна.

ОБЪЕКТ 99572





ТХБ-ЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ТУССАН БАЙДАЛ: БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөртэй холбоотой баримт бичгийн хүрээнд)

УДИРТГАЛ

Монгол улсын боловсрол, сургалтын үндсэн баримт бичгүүдэд ТХБ-ын үзэл баримтлал, арга хандлага тусгагдсан байдлыг илрүүлж, санал зөвлөмж боловсруулахад шинжилгээний зорилго оршино.

Шинжилгээний ажлын үр дүнг 2024 онд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэх ажлын (сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, чиглэлийг тогтоох... г.м) хүрээнд эх сурвалж болгон хэрэглэнэ.

АРГА АРГАЧЛАЛ

Шинжилгээг хийхдээ 1. ТХБ-ын үзэл баримтлал/хандлага туссан байдал, 2. ТХБ-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх механизм/менежментийг тусгасан, зохицуулсан байдал, 3. ТХБ-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх механизм/менежментийг тусгасан, зохицуулсан байдал гэсэн үндсэн шалгуур, тус бүрд нь 2-4, нийт 9 үзүүлэлтийг тогтоон ашиглалаа.

Шалгуур	Илрүүлэх үзүүлэлт
Шалгуур 1: ТХБ-ын үзэл баримтлал/хандлага туссан байдал	Тэгш хамран сургалт/тэгш боломж
	Насан туршийн суралцахуй
	Чанартай боловсрол
	Жендерийн тэгш байдал
Шалгуур 2: ТХБ-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх механизм/менежментийг тусгасан, зохицуулсан байдал	Хэрэгжилтийг хангах байгууллага/институт
	Талуудын оролцоо, хүлээх үүрэг, хариуцлага
	Хэрэгжилтийг удирдах үйл явц: засаглал
Шалгуур 3: ТХБ-ын хэрэгжилтийн болон үр дүнгийн үнэлгээ/эргэх холбоог тусгаж, зохицуулсан байдал	Хэрэгжүүлэх үйл явц: менежмент - төлөвлөлт/хэрэгжүүлэлт
	Үр дүнг үнэлэх шалгуурыг тогтоосон байдал
	Мэдээлэл цуглуулах механизм, хариуцах субъект тодорхой эсэх

ҮР ДҮН

БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН

Урт хугацааны бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээнээс үзэхэд нийт 6 зорилтод ТХБ-ын үзэл баримтлал тусгагджээ. Мөн 6 зорилтод ТХБ-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох, хүний нөөцийг хөгжүүлэх зэргээр менежментийг тусгасны зэрэгцээ үнэлгээ шалгуурын хувьд нийт 6 шалгуур үзүүлэлтийн олонх нь тэгш хамран сургах болон боловсролын чанарыг үнэлэхэд чиглэсэн байна. Эдгээрээс 65.2 хувь нь (46) ТХБ-ын үзэл баримтлалыг тусгасан, “шууд хамаарч агуулгын хувьд уялдсан” байна. Харин ТХБ-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх менежментийг тусгасан байдал болон ТХБ-ын хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээ/эргэх холбоог тусгаж, зохицуулсан байдал нь 18.1.0-33.3 хувийн нийцтэй байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичигт бага, дунд боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийн бодлогод хамаарах нийт 123 арга хэмжээ, тэдгээрийг үнэлэх 9 үзүүлэлт тусгагдсан байна. Шинжилгээнээс үзэхэд шалгуур 1-ийн хүрээний жендерийн тэгш байдлыг хангах, насан туршдаа суралцахуйн асуудал бусад үзүүлэлттэй харьцуулахад бага буюу 17 хувьтай байна.

Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай хуульд ТХБ-ын үзэл баримтлал, хандлагыг илэрхийлсэн тэгш хамран сургах тэгш боломж, насан туршийн суралцахуй, чанартай боловсролын тухай заалтууд шууд ба дам хамааралтай байдлаар тусгагдсан байна, Эдгээр хуульд жендерийн тэгш байдлын талаарх зүйл, заалт тусгагдаагүй байна.

СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖИЙН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН

ЮНЕСКО-оос Монгол Улсын 2019 онд хийсэн Боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлан нь бүхэлдээ насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх, боловсролын салбарт тэгш байдлыг хангах асуудалд чиглэсэн байх бөгөөд бага, дунд боловсролын салбарт шууд ба дам утгаар хамаарах нийт 37 зөвлөмж өгсөн байна. Бидний судалж буй асуудал Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээний зөвлөмжид тусгагдсан байдлыг “тэгш хамран сургах/тэгш боломж, насан туршдаа суралцахуй, чанартай боловсрол, жендерийн тэгш байдал” гэсэн 4 үзүүлэлтэд хамааруулан авч үзэхэд нийт 11 зөвлөмж агуулгын хувьд хамаарч байна.

Монгол Улсад 2015 оноос хойш боловсролын чанарыг сайжруулах, өнөөгийн нөхцөл байдал, үйл явцыг үнэлж тодруулах зорилгоор хийгдсэн судалгааны тайланг сонгон аргачлалын дагуу үнэлж үзэхэд нийт 104 хамаарах үзүүлэлт бүртгэгдсэн бөгөөд үүнээс “шууд хамаарах” 56.7 (59), “агуулгын хувьд уялдсан” 38.5 хувь (40) буюу “дам хамааралтай”, “хамааралгүй” үзүүлэлт байхгүй хэмээн тодорхойлогдсон.

ШИНЖИЛГЭЭНД АВСАН БАРИМТ БИЧИГ

Бодлогын баримт бичиг	Шинжлэх судалгааны тайлан
<ul style="list-style-type: none"> Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020-2050, (хав 1, 2, 3) Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030) Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр ТХБ-ын үндэсний хөтөлбөр 	<ul style="list-style-type: none"> Монгол улсын ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан. Боловсролын бодлогын тойм шинжилгээ, зөвлөмж Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа. МУ-ын ТХБ, ТХ, Ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгааны тайлан “Хорин нэгдүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшнээр тогтоох нь” судалгааны урьдчилсан тайлан

ДҮГНЭЛТ

Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүд болон зарим эрх зүйн актад хийсэн шинжилгээнээс үзэхэд эдгээр баримт бичгүүд нь нь хоорондоо уялдаа холбоо бүхий боловсруулагдсан сайн талтай байна. Мөн эдгээр бодлогын баримт бичигт ТХ, ТХБ-ын үзэл санааг шингээсэн байх бөгөөд боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны бодлого, төлөвлөгөө боловсруулах нэг үндэс нь ТХБ-ын хөтөлбөр болсон гэж үзэхээр байна.

Боловсролын салбарын дунд хугацааны бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдэд суурилан цаашид гаргах бодлого шийдвэрийн үндсийг боловсруулах, сайжруулах ажил хийгдэх шаардлагатай нь шинжилгээ хийхэд ажиглагдаж байна. Ялангуяа, боловсролын багц хуулийн шинэчлэл хийгдэж буйтай холбоотой нарийвчилсан болон шинэ зохицуулалтыг тусгах шаардлага байна. Мөн

бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа жендерийн тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг тодруулж явах нь зүйтэй байна. Учир нь боловсролын салбарын багш ажиллагсдын хүйсийн харьцаа алдагдсан, ерөнхий боловсролд хөвгүүдийн сурлагын амжилт анхаарал татахуйц сул байгаа, бодлогод жендерийн тэгш байдлыг хангах зорилт сул байгаа зэргээс харагдаж байна.

Шинжилгээнээс үзэхэд шалгуур 2 буюу “талуудын хүлээх үүрэг, хариуцлага хэрэгжилтийг хангах байгууллага/институт, хэрэгжилтийг удирдах үйл явц: засаглал”-тай холбоотой үзүүлэлтэд холбогдох бодлого, үйл ажиллагаа хамгийн цөөн илэрцтэй байсан нь хангалттай сайн бодлого боловсруулж, зорилт дэвшүүлдэг боловч түүнийг хэрэгжүүлэх тал дээр хангалттай анхаараагүй байна гэж үзэхэд хүргэж байгааг тэмдэглэж байна.

ДЭЛХИЙН ЭХ ХЭЛНИЙ ӨДӨРТ

ЖИЛД ДУНДЖААР 18 ХЭЛ МӨХӨЖ БАЙНА

Дэлхийн хүмүүсийн 40 хувь нь хятад, испани, англи, араб, хинди хэлээр, харин 60 хувь нь 6900 гаруй хэлээр ярьж байна. Эдгээр хэлний түрүүнд протугали, бенгал, орос, япон, герман, франц зэрэг хэл орж байгаа юм. Мөн сүүлийн үед хятад хэлний хэрэглээ өсчээ. Хэл шинжээчдийн тооцоогоор нэг жилд дунджаар 16-18 хэл мөхөж байна. Ийм байдлаар 2100 он гэхэд одоо ярьж байгаа 6900 гаруй хэлний 50-аас дээш хувь нь мөхөх төлөв байна.

Америкийн Хэл шинжлэлийн институтийн “Этанологи” сэтгүүл.

ЭХ ХЭЛ НИЙГМИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛДАГ

Энэ жил НҮБ-ын ЮНЕСКО Эх хэлний олон улсын өдрөөр эх хэлний нэгтгэх чадварыг онцлолоо. ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Одри Азулей хэлсэн үгэндээ “Эх хэл нь тухайн хэлээр яригчдыг нэгтгэн ойртуулж, нийгмийн нэгдэл нягтрал, инновац, уран сэтгэмжийг бий болгодог. ЮНЕСКО-ийн судалгаагаар өөрийн биш хэлээр боловсрол эзэмших нь суралцахууд саад учруулаад зогсохгүй тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг нь тогтоогдсон” гэж байлаа.

ЮНЕСКО-оос эх хэл соёлын олон янз байдал, эх хэлний талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Эх хэлний ОУ-ын өдрийг 1999 оноос эхлэн жил бүр хоёрдугаар сарын 21-нд тэмдэглэж ирсэн уламжлалтай. Тус байгууллагын судалгаагаар, дэлхийн хүн амын бараг 40 хувь нь өөрийн ярьж, ойлгодог хэлээрээ сурч чадахгүй байна.

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ОРШИХУЙН ДАРХЛАА

МУ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО “АЛСЫН ХАРАА 2050”

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол хэл, бичгээ үндэсний нэгдмэл үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвших зорилт дэвшүүлсэн нь “Тогтвортой хөгжлийн зорилго 2030” хөтөлбөрийн 4 дэх зорилт буюу Чанартай боловсролын зорилттой уялдан гэж Монгол улсын Засгийн газар үзэж байгаа юм. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогод суурилсан дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтөд ч энэхүү зорилтыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байгаа нь хэнийг ч орхигдуулахгүйгээр хамтдаа хөгжих “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын үндсэн зарчимтай нийцсэн. Монголчууд эх хэлээрээ сурч боловсрох, эх хэлээрээ чанартай боловсрол эзэмших, эх хэлээрээ бахархах, дэлхий дахинаа сурталчлан таниулах гээд Тогтвортой хөгжлийн агуулга, зарчмыг тусгасан гэж үзэж байна.

ЭХ ХЭЛНИЙ ТУХАЙ ТЭД ...



ЮНЕСКО-ийн ерөнхий захирал Одри Азулей: Сургуульд суралцах эхний жилүүдэд унших, бичих, тоо бодох зэрэг үндсэн чадварыг эзэмшин бичиг үсэгт тайлагдахад эх хэл чухал үүрэгтэй. Эдгээр чадвар нь хувь хүний хөгжлийн үндэс суурь болдог. Эх хэл нь тухайн үндэстний уламжлах, бүтээх сэтгэлгээний өвөрмөц илэрхийлэл төдийгүй мэдлэг, инновацийн эх булаг юм.



Баги, судлаач Г.Баттогтох: Үсгийн дүрэм гэдэг яг л замын хөдөлгөөний дүрэмтэй адил. Үсгийн дүрмийг үл хэрэгсэж байна гэдэг бол улаан гэрлээр гүйж буй хүнтэй адилхан. Их л бүдүүлэг харагддаг.



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич Л.Болд: Эх хэл гэдэг эхээс сурсан хэлээрээ яриарай гэсэн утгатай юм шиг байна. Монгол хэлнийхээ мөн чанарыг улам гүнзгий, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдсэнээр ирээдүйн монгол хэлээ шинжлэх ухааны үндэстэй харна гэсэн үг.



Хэл бичгийн ухааны доктор, профессор Ц.Өнөрбаян: Явж байна” гэж бичих нь хэлний хөгжлийг хазаарлаж байгаа хэрэг. Хэл аман яриаг дагаад хэт хурдан хөгжсөнөөр бичгийн хэл хурдан устах аюултай.



Хэл бичгийн шинжлэх ухааны доктор (sc.d), профессор С.Дулам:

ОУ-ын Эх хэлний өдрийг тохиолдуулан хэл бичгийн шинжлэх ухааны доктор (SC.D), профессор С.Дуламаас зарим зүйлийг тодрууллаа.

Эх хэлний хэрэглээтэй холбоотой асуудал гэвэл өнөөгийн нөхцөлд олон бий болов уу. Яг өнөөдрийн хувьд бид юунд илүү анхаарал хандуулах ёстой гэж үзэж байна вэ?

ЮНЕСКО-гийн Ерөнхий Захирал Одри Азулей ОУ-ын эх хэлний өдрөөр дэлхий нийтэд олон хэлний хэрэглээг хөхүүлэн дэмжих уриалга гаргалаа. Өнөөдөр дэлхий нийтэд тулгарсан цар тахлын улмаас анги танхимаасаа холдсон 1.5 тэрбум суралцагсад алсын зайн буюу цахим сургалтын хүртээмжгүй нөхцөл байдал ороод байгааг мэдээлсэн байна. Тиймээс ч боловсролын үйлчилгээнд

С.ДУЛАМ: МОНГОЛ ХЭЛ ХАРИЙН ЯМАР Ч ҮГИЙГ “ЭХ БАРИХ” БАЯН ТАНСАГ ХЭЛ

иргэдийг тэгш хамруулах, хэнийг ч орхилгүй хамтдаа хөгжих Тогтвортой хөгжлийн зарчим хаа сайгүй зөрчигдөж байна.

Цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа энэ асуудал нь эх хэлний хэрэглээнд ихээхэн хамаатай. Манайд ч мөн адил. Цахим орчин, техник хэрэгслийн хүрэлцээгүйгээс болоод суралцагсад хичээлээс хоцрох нь анхааруштай асуудал. Харин Монгол Улсын иргэд эх хэлээрээ боловсрол эзэмших боломж нөхцөл харьцангуй сайн байна.

Цахим орчинд эх хэлээрээ зөв бичиж, харилцахыг та өнгөрсөн жил уриалж байсан. Үүн дээр яаж өөрчлөлт гаргах вэ?

Энэ бол хүн бүрийн анхаарч, өдөр тутмын хэрэглээ болгох учиртай асуудал. Ялангуяа мэргэжлийн сэтгүүлчид, багш нар энэ талаар бусад цахим хэрэглэгчиддээ үлгэр жишээ үзүүлэх шаардлагатай байгаа юм.

Гаднын үг хэллэгийг орчуулж хэрэглэх тал дээр янз бүрийн санал гардаг. Зарим нь гаднын шинэ нэр томъёог монголоор орчуулснаар үндсэн утгаа гээж болгоомжилдог.

Бид Улсын нэр томъёоны комиссын 1921-1979 оны хооронд тогтоосон нэр томъёоны дөрвөн боть, 115 мянган нэр томъёог монгол хэлээр толгойлж удахгүй хэвлүүлэн гаргах гэж байна. Үүн дээр үндэслээд төрөл бүрийн шинжлэх ухааны салбарын нэр томъёоны орчуулгын сан бүрдүүлж байна. Нэг хэсэг завсарласан Улсын нэр томъёоны комиссыг сэргээн байгуулаад мэргэжлийн салбарууд нь шинэ нэр томъёогоо цэгцэлж түүрүүчээсээ хэвлүүлж эхлээд байна.

Ер нь монгол хэлнээ гадаад үг орж ирэхэд боломжоор нь орчуулахыг хичээх хэрэгтэй. Тухайлбал, бид 1980-аад оны сүүлээр “плюрализм” гэдэг үг орж ирэхэд үгийн гарал утга, бүгдийг шинжлээд “олон ургальч үзэл” гэж орчуулсан. Таван хэлний толиноос олсон үг л дээ. Уг үг нь ургамал судлал, геологийн эрдсийн нэр томъёотой холбоотой “ургаль” гэдэг үг. Энэ утгыг шилжүүлэн авч хэрэглээд “олон ургальч үзэл” гэдэг нэг томъёо



гаргасан маань амжилттай болж монгол хэлний хэрэглээнд энэ үг бүрэн орсон шүү дээ.

Мөн “globalization” гэдэг үг орж ирэхэд “Монголын нууц товчоо”нд байгаа “Наран ургахуйгаас шингэхүй хүртэлх даян иргэн” гэдэг хэллэгийг хэл зүйн хувиргалаар хувиргаад “даяаршил” гэдэг монгол үгийг бий болгосон. “Даяар” гэдэг бол тэр чигээрээ дэлхийн бөмбөрцгийг тойрч байгаа утга, мэдрэмжийг төрүүлдэг. Харин “даяарчлах” гэвэл хүч түрсэн утгатай болно. Жам ёсны дагуу болж байгаа үйл явцыг монгол хэлэнд “-ших” гэсэн дагавраар илэрхийлдэг.

Ингэж монгол хэл харийн ямар ч үгийг өөртөө эх барьж авах нөөц, чадвартай баян тансаг хэл юм. Донж нь таараад ирэхээрээ харь үгс ийнхүү үгсийн санд амархан нэвтэрдэг.

Дэлхий дээр өнөөдөр 10 сая орчим хүн монгол хэлээр ярьж байна. ЮНЕСКО-ийн шалгуураар тухайн хэлээр зөвхөн настайчууд нь ярьдаг, залуу хүн ам нь ярихаа больсон хэлийг мөхөж байгаа хэл гэж үздэг. Энэ шалгуураар бол монгол хэл мөхөж байгаа хэлэнд хамаарахгүй. Тэгэхээр хэлний хэрэглэгчид олон байх, залуу байх нь нэн чухал. Тэр дундаа бидний хойч үе монгол хэлээрээ хэлд орж, монгол хэлээрээ ярьж, суралцаж байх нь онцгой чухал юм.

Танд баярлалаа.

“ЗАН ЗАНШЛЫН ӨРГӨӨ”-ТЭЙ БОЛЛОО



Хэнтий аймгийн Галшар сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш зан заншлын өргөө байгуулах төслөөрөө “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” /ТХБ/ төсөлд шалгарсан юм. Тэд таван ханатай гэрт өргөөгөө байгуулаад байна. Монгол гэртээ эрт монголчууд хэрхэн аж төрж ирснийг биетээр харуулахын зэрэгцээ ханын ам нийлүүлэхээс эхлээд гэр барих нарийн аргыг сурагчдад заах юм байна. Мөн өргөөнд шагайн харваа, хасаа, шагай зэрэг монгол наадгай, сур элдэх, ногт зангидах зэрэг монгол ахуйн үйлийг зааж, үлгэр домог, оньсого хэлэлцэж, морины гийнгоо цолыг зааж

сургахаар төлөвлөжээ. Ингэж монгол зан үйлээр хүүхдүүдийг сурах арга барилд сургаж, монгол ахуй үйлийн учир холбогдлыг ойлгуулахыг зорьсноо Хэнтий аймгийн Галшар сумын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Оргил ярилаа. “ТХБ-II” төсөл бидэнд их сайхан боломж олголоо. Манай төсөл нь монгол зан үйлийг сэргээх, түүгээр дамжуулан хүүхдүүдэд эерэг зөв хандлагыг төлөвшүүлэхэд том нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Бусад сумынхаа хүүхэд багачуудыг ч энэ өргөөндөө сургана” гэлээ. Хэнтий нутгийнхан гал шаргын хурдан удмын адуутай. Тиймээс ч морь цоллох, гийнгоолох эрдмийг ч сурагчиддаа Зан заншлын өргөөндөө зааж сургах юм байна. Ихэвчлэн нутгийн өв соёл тээгч ахмадууд багшилна гэлээ.



“ХУДАЛДАН АВАЛТГҮЙ ӨДӨР” ӨӨРӨӨ ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛНА



Хэнтий аймгийн Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургууль сурагч, багш, эцэг эхчүүдийнхээ дунд судалгаа хийхэд хог хаягдлыг бууруулж, цэвэр цэмцгэр орчинд амьдрах хандлагыг төлөвшүүлэхийг хүсчээ. Ингээд тус сургуулийн багш, сурагчдын төлөөлөл хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах, дахин ашиглах зэрэг зөв дадал хэвшилд суралцах, энэ чиглэлээр сумынхаа иргэдийг уриалах, тэдэнд нөлөөлөх зорилготой “Цэвэр цэмцгэр бидний орчин” төслийг санаачилсан

нь “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөлд шалгарсан юм. Сургуулийнхаа дахивар хог хаягдал хуванцар сав цуглуулж тушааж хэвшсэн ажлаа “ТХБ-II” төслөөр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Мөн сумынхаа бүх байгууллагад хог хаягдлын хор уршгийг таниулж, хогоо зөв ангилан ялгах талаар мэдээлэл хүргэж, экологийн ул мөрийн судалгааг хийгээд байна. Хойшид сургуулийнхаа орчинд хог ангилан ялгах савнууд байрлуулах, ухаалаг, ногоон худалдан авалт хийх дадал хэвшилээ сэргээх зэрэг ажил хийнэ гэж Баян-Адарга сумын сургуулийн багш нар ярилаа.

Shuree Dawatsend - Баян-Адарга Сум Сургууль

ТХБ-2 төсөлд хамрагдаж буй Хэнтий аймгийн Баян-Адарга сумын ЕБС-ийн “Цэвэр цэмцгэр бидний орчин” төслийн баг төслийн танилцуулга мэдээллээ бэлтгэж байна.



Shuree Dawatsend - Баян-Адарга Сум Сургууль

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын ЕБС-ийн ТХБ-2 төслийн баг нь сумын 12 ААН байгууллагуудад “Цэвэр цэмцгэр-бидний орчин” төслийн талаарх танилцуулга, брошюрыг байршууллаа.



Баян-Адарга сумын сургуулийн захирал Б.Анхбаяр “Сурагч, багш нар сумаа цэвэр цэмцгэр болгох ажлыг сургуулиасаа эхэлжээ гэж санаачилж, “ТХБ-II” төслийн дэмжлэгийг хүлээгээд байна. Хогоо бууруулахад зөв худалдан авалт, эрүүл хооллолт ч чухал. Эцэст нь бид хүүхдээр дамжуулж эцэг эх, айл өрхөд хогоо бууруулж, ангилан хаядаг байх, дахин ашиглах, эрүүл зөв хооллодог байх зэрэг дадал хэвшлийг тогтоохыг хүсч байгаа юм. Ингэснээр Баян-Адарга сумынхаа хог хаягдлыг бууруулж чадна” гэлээ.

ХОГ ХАЯГДЛАА БУУРУУЛАХ ЦАХИМ СУРГАЛТАА ЭХЭЛЛЭЭ



Хэнтий аймгийн Хан Хэнтий цогцолбор сургууль хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах, дахивар хог хаягдал болох хуванцар сав цуглуулж сар бүр “Баялаг Хурх” ХХК-д тушаах зэрэг ажлыг “ТХБ-II” төсөлд шалгарсан жижиг төслөөрөө хийж хэрэгжүүлнэ. Энэ төсөлдөө сумынхаа нийт хүн амын 20 хувийг хамруулахаар зорьжээ. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгаж сурах, сурталчлах зорилготой багш нарын шалгарсан бүтээлүүдийг цахимд /Youtube/ байршуулаад байна. Мөн ухуулах зурагт хуудсыг сумын иргэд, айл өрхөд тарааж, хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа сурталчилж эхэллээ.



“ЭРҮҮЛ ХҮНС, ЭНХ АМЬДРАЛ” ТӨСЛӨӨР БУРУУ ХООЛОЛТЫГ ӨӨРЧИЛНӨ

“ТХБ-II” төсөлд “Эрүүл хүнс, энх амьдрал” төслөөрөө шалгарсан Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын “Тэмүүжин” цогцолбор сургууль төсөл хэрэгжүүлэх санхүүжилтээ аваад байна. Цогцолбор сургуулийн захирал М.Золзаяагаас төслийн талаар тодрууллаа.

Төслөөр хичнээн иргэдийг хамруулж, ямар үр дүн гаргахыг зорьж байна?

Манай хамт олон “ТХБ-II” төсөлд хамрагдан ТХБ-ын загвар сургууль болохоор төслийн баг хамт олны чиглүүлгээр багш сурагчид, удирдлага, эцэг эхчүүд бүхлээрээ хамтран суралцаж, хөгжиж байгаадаа туйлын их баяртай байгаа. Бид төсөлдөө сургуулийн сурагчдын



70 хувь, нийт эцэг эхчүүдийн 40 хувийг хамруулахын зэрэгцээ багш ажилтнуудаа бүрэн хамруулахаар төлөвлөсөн. Нийтдээ багцаагаар 250 өрх, 500 орчим эцэг эх хамрагдана. Гол зорилго нь хүүхэд залуус, гэр бүл, эцэг эхчүүдэд эрүүл энх амьдрахын тулд зөв хооллох ёстой юм байна гэдгийг ойлгуулж, хэрэглээ сонголтдоо зөв болгох, үүний төлөө хамтдаа хичээхийг уриалж, үлгэрлэн дагуулах юм.

Тус төсөл хэрэгжүүлэх санаачилга хэрхэн өрнөсөн бол?

Сургуулийн орчинд гарч байгаа хог хаягдлыг ангилж, судлахад хийжүүлсэн ундаа, жүүс, гоймонгийн сав, хуушуур прошкины тостой цаас зэрэг хагас боловсруулсан бүтээгдэхүүний сав, боодол нийт хог хаягдлын 30 гаруй хувийг эзэлж байсан. Энэ нь манай багш, сурагчдын өдрийн хоол хүнсний хэрэглээ буруу байгааг нотолж байна. Мөн их завсарлагаанаар зарим сурагчид ойр орчмын дэлгүүр, цайны газраас дээрх бүтээгдэхүүнүүдийг худалдан авч байгаа нь ил байсан. Мөн эцэг эхчүүд хүүхдэд өдөр бүр бэлэн мөнгө өгч явуулснаар тэдний хэрэгцээг хангаж байгаа биш, харин ч эрсдэл рүү түлхэж, эрүүл мэндийг нь хохироож байгааг зогсоох зайлшгүй хэрэгцээ урган гарсан.

Ер нь “ТХБ-II” төсөл орон нутагт үр дүнтэй хэрэгжих ямар боломж бололцоо бий гэж үзэж байна?

ТХБ төсөл нь нас, хүйс, мэргэжил боловсрол харгалзахгүй хүн бүрт хэрэгтэй мэдээ мэдээлэл, ойлголтыг өгч, насан туршид нь хэрэглэгдэх, зөв хэрэглээ зөв сонголт, зөв хандлага төлөвшүүлэх, өөрийгөө болон гэр бүлээ, өнөөдрийг болон ирээдүйгээ аврах амьдрах ухааны хамгийн чухал сургалт-нөлөөлөл гэж боддог.



Бусад төсөл зөвхөн нэг удаагийн зорилгыг хангахад чиглэдэг бол ТХБ төсөл насан туршийн зорилгыг хангахад чиглэдэг. Төсөл хэрэгжсэнээр орон нутагт хүрээлэн буй орчноо хамгаалах, хог хаягдлыг бууруулах, хэрэглээгээ зохистой болгож, сонголтдоо анхаарах, ус эрчим хүчний хэрэглээг зөв зохистой байлган алдагдал үргүй зардлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд гэр бүл хамт олноороо санаачилгатай оролцдог болж байгааг зэрэг ололттой зүйл олон байна. Тухайлбал манай аймагт төрийн бүх байгууллагын талбайн эзлэхүүнийг дахин тооцож хэмжсэн, дулааны тоолуур тавьж байгаа зэрэг нь үргүй зардлыг бууруулж, төсвийн хуваарилалт, зарцуулалт оновчтой болж, эдийн засгийн хэмнэлт гарч, шаардлагатай асуудлаа шийдвэрлэх боломжууд бий болж байгаа жишээ байна.